

★ Төгөлдөр богд хүн бол бүрэн бүтэн хүн юм. Төгөлдөр хүн лавтай ариун байдаг. Одоо бид зөвхөн хагасхан хүн л төдий юм. Бид ажил явдлыг шийдвэрлэхдээ эрс шуурхай биш, мужуу баримтлалаараа шийдвэрлэдэг. Хаан хурмаст биднийг тоглуулахын төлөө, биднийг зүйл зүйлийн ойлголттой болгохын төлөө түмэн бодисыг үүдэв гэж бид итгэхгүй. Бид муу, сайн гэж ялгадэг. Юм бүхэнд атаархдаг бөгөөд үүнээрээ бусад хүнийг бас ийм гэж боддог. Хаан хурмастын ажлыг хязгаарладаг учраас бид зовлон амсаж байна. Ойлгов уу? Хаан хурмаст бидний дотор оршин байвч бид түүнийг хязгаарлахыг оролддог. Бид баярлан цэнгэх дуртай боловч яаж цэнгэхээ мэдэхгүй. Бид бусад хүнд "Аа, та тэгж

болохгүй" гэж хэлдэг, өөрийн биедээ " Би тэгж болохгүй, би ингэж болохгүй, би юунд бацаг барих хэрэгтэй вэ?" гэж хэлдэг. Юунд бацаг барихыг би мэдэж байна. Би бацаг барьж байгаа нь миний дотоод дахь хаан хурмаст намайг ингэж хийгтүн гэжээ.

—Auma Ching Hai—

★ Миний бие, хэл, сэтгэл нэг секунд гэсэн ч цэвэрхэн байх үед буй бүхий тэнгэрийн хүмүүс, арш, тэнгэрийн зарц нар бүр ирж намайг дэмжих юм. Тэр үед бүхий л орчлон цөм манайх юм, цөм биднийг дэмжих юм. Эрдэнийн суудал ч биднийг хүлээж байх юм.



ЮУНД БАЦАГ БАРИХ ТУХАЙ

Насан турш бацаг барих явдал бол сэтгэлийн авишиг хүртэж Арьвалын номын цогцсыг бясалгахын тэргүүн нөхцөл болно. Ургамал бодис ба цагаан идээний зүйлийг идэж болдог. Амьтнаас гаралтай буй бүхий идээний зүйлсийг идэж болохгүй (өндөг оролцоно). Үүнд олон сургаал байдаг, хамаг чухал нь нэгдүгээр сахил "Та нар амьтныг хороож болохгүй" гэдэгт амьтны амийг хороохыг цээрлэсэн байна. Амьтныг хороохгүй буюу бусад амьтныг хорлохгүй гэдэг нь амьд бодист яриангүй ашигтай. Бусдын амийг хорлохгүй гэдэг нь Үнэндээ манай өөрийн биед бас ашигтай байдэг. Яагаад ингэж хэлдэг юм бэ? гэвэл, Үйл Үрийн

жам хуульд " ямар Үйлийг таривал тийм Үрийг хураах " гэж байна. Та өөрийн идэш уушаа хангахын тул амьтныг хороох, эсхүүл бусад хүн таны төлөө амьтныг хороовол, амь хороосон Үйлтэй болж, энэхүү Үйл түйтгэрээ эцэстээ буцааж төлөх хэрэгтэй болно.

Чухамдаа бацаг нь өөрийн биедээ ашиг олгож байгаа явдал мөн гэж хэлж болох юм. Бацаг барих нь манай биед хуримтлагдсан өр, хүнд Үйл түйтгэрээ хөнгөлөх уучраас манай амьдрал сайжирч сэрэлт улам хурц болж дотоодод нь орж улам гүн нарийн ойлголттой болж, шинэ сайхан жаргалант орныг олж харах болно. Энэ нь бацаг барьж өчүүхэн төдий Үрэгдэл гаргах нь танд ашигтай гэснийг гэрчилж байна.

Билэгт чанарын Үзлээр мах идэхийг эсэргүүцдэг нотлол зарим хүмүүсийг

бишрүүлдэг байна. Үүнээс бус бацаг барихыг дэмжсэн ёс бас байдаг. Ёс бүхэн нь цөм ерийн мэдлэгээс үүсэлтэй байна. Жишээлбэл хүний эрүүл мэнд ба шим тэжээл, амьд бодисын орчин ахуй, иш ёс суртахуун, амьд бодисын хордогдол, дэлгийн гамшиг зэрэг.

ЭРҮҮЛ МЭНД БА ШИМ ТЭЖЭЭЛ

Хүн төрөлхтний хувьсан хөгжсөн түүхнээс үзэхэд манай өвөг дээдэс төрөлхийн бацаг баригчид байжээ Хүн төрөлхтний бие махбодын бүтэц махан идээнд зохицохгүй юм. Колумби их сургуулийн доктор Ханьдин (Dr. G. S. Huntington) харьцуулсан задлахуй ухааны өгүүлэлдээ үүнийг номлосон байна. Түүний хэлсэн нь: Мах иддэг

амьтны нарийн гэдэс ба бүдүүн гэдэс нь цөм бүдүүн бөгөөд богино, бүдүүн гэдэс нь онц шулуун бөгөөд гулгуур юм. Үүний эсрэгээр бацаг иддэг амьтны нарийн, бүдүүн гэдэс нь цөм урт, махны ширхэглэг цөөн, уураг өндөр байдаг учраас гэдэс нь шим тэжээлийг аажмаар шингээх чухалгүй. Ийм чучраас мах иддэг амьтны гэдэс нь бацаг идэгч амьтны гэдэснээс богино юм.

Хүн төрөлхтөн бацаг идэгч бусад амьтантай адилаар бүдүүн гэдэс ба нарийн гэдэс нь цөм урт байдаг. Бидний гэдэс бараг 28 фут (8.5 метр) урт юм. Нарийн гэдэс нааш цааш нугаларч, гэдэсний хана хуниастай бөгөөд гулгуур биш байдаг. Энэ нь мах иддэг амьтны нарийн гэдэснээс нэн урт байх учир бидний идсэн мах гэдсэн дотор удаан байж ялзран хорт бодис үүсгэдэг. Эдгээр хорт бодис олгойн

өмөн өвчин Үүсэхтэй холбогдолтой байдаг. Үүнээс гадна бас хор дарах чадвар бүхий элэгний ачааллыг нэмэгдүүлж, элгийг хатууруулж, цаашилбал элэгний өмөн өвчин олгодог. Махны дотор шээсэн гормоны исгүүр ба шээслэг эд маш арвин агуулагдаж, бөөрийн ачааллыг нэмэгдүүлж, бөөрийн чадварыг эвддэг. Нэг фунт хэрчмэл Үхрийн маханд 14 грамм шээсэн гормон агуулагдаж байх юм. Амьд эсийг шээсэн гормоны исгүүрийн уураг дотор дэвтээвэл шинэ хуучны солилцоо хийх чадвар нь мууддаг байна. Махны зүйлд ширхэглэг эд ба ширхэглэг бодис дутагддаг бөгөөд ширхэглэг бодис дутагдвал өтгөн мөр амархан хатах болно. Олны мэдээжээр, өтгөн мөр хатах нь бүдүүн гэдэсний өмөн буюу шамбарам өвчин амархан олдог юм.

Махны доторхи цөсний алкоголь ба ханамал өөх бас зүрхэн судасны өвчин үүсгэдэг. Зүрхний судасны өвчин бол америкчуудын нэгдүгээр үхэл арвинтай өвчин болно. Тайваньд одоо хамгийн үхэл арвинтай өвчин бас л энэ өвчин болно. Өмөн бол амархан үхэх хоёрдугаар өвчин болох юм. Туршилтыг үндслэвэл, шарсан маханд нэг зүйлийн химийн бодис үүсдэг (Methylsholanthrene), энэ бол өмөн болох бодис юм. Энэ химийн бодисыг хулганад идүүлбэл хулгана өмөн өвчин олдог байна, жишээлбэл, ясны өмөн, цусны өмөн, ходоодны өмөн зэрэг.

Шинжилгээнээс үзвэл, хөхийн өмөн олсон хулганын хөхүүлж байгаа зулзага нь бас өмөн өвчин олох аюултай байдаг байна. Хүний өмний эсийг амьтанд таривал амьтан бас өмөн өвчин олох аюултай байдаг. Манай өдөр тутмын

иддэг маханд угаасаа өвчинтэй малын мах тохиолдож мэдэх тул бид бас өвчин олох бололцоо их байдаг билээ.

Олонхи хүмүүс алшны мах ариун цэвэр юм, мал алах газар цөм шалгаж байдаг гэнэ. Мал алах газар өдөр бүр тийм арвин үхэр, гахай, тахиа, нугас... зэргийг алж худалдаж байх тул нэг нэгээр шалгах арга байхгүй юм. Нэг хэсэг маханд өмний эс байх эсэхийг шалгаж олоход туйлын хүчир байна. Амьтан бүхнийг нэг нэгээр шалгана гэдэг чинь худал үг. Махны үйлдвэр, толгой нь сэжигтэй бол тогойг нь хаяж, хөл нь өвчинтэй бол хөлийг нь хаях арга хэрэглэж, зөвхөн өвчинтэй хэсгийг нь хаяад бусад үлдсэн хэсгийг нь мөн худалдаж байна.

Алдарт бацаг баригч эмч, доктор Кело (Dr. J. H. Kellogg) " Бид бацаг

баривал идэшний зүйл бидэнд ямар өвчин авчирч өгөх бол? гэж сэтгэл зовох хэрэггүй. Энэ чинь хүмүүс идэж уухдаа хэдий тавтай сайхан бэ?" гэж хэлжээ.

Үүнээс гадна бас нэг зүйлийн эргэлзэл байдаг. Амьтны тэжээл бордоонд бактер дарах эд болон бусад зүйлийн цөсний алкоголь, өсгөх гормон зэргийг холих юм. Амьтанд бас эдгээр зүйлийг шууд тарьдаг. Хүн эдгээр амьтны махыг идвэл эдгээр бактер дарах эмийг шингээж авах тул эмчигээчд хэрэглэсэн бактер дарах эд аяндаа хүчингүй болно гэж шинжилээнд гарсан байна.

Зарим хүмүүс бацаг баривал шим тэжээл хүрлцэхгүй болно гэж байна. Америкийн гэмтэл согогийн эмнэлгийн мэргэжилтэн, доктор Милэ (Dr. Miller) Тайваньд эмнэлэг байгуулж 40 гаруй жил болжээ. Эмнэлгийн бүх ажилтад болон

өвчтөн цөмөөрөө бацаг барьдаг байна. Түүний хэлсэн нь: "Хулгана бацаг идэх буюу мах идэж бүр амьдарч чадах амьтан юм. Хоёр хулганыг салган хорьж, нэгд нь мах идүүлж, нэгд нь бацаг идүүлэхэд хоёр хулганын өсөлт бойжилтын байдал их төлөв адил байдаг. Гэвч бацаг идсэн хулганын нас нь нэлээд урт, өвчин эмгэгтэй тэмцэх чадвар бас нэлээд сайн юм. Хоёр хулгана өвчин хүрсний дараа бас л бацаг идсэн хулганын эдгэрэх нь хурдан байдаг" гэжээ. Тэр бас "Орчин цагийн шинжлэх ухааны хишгийг хүртсэний ачаар эмнэлгийн нөхцөл маш сайжрав. Гэвч эмийн зүйл бол зөвхөн хүний өвчнийг эмнэнэ, хүнсний зүйл бол хүмүүсийг эрүүл мэнд байлгаж чадна" гэж хэлсэн байна. Бас хэлсэн нь: Ургамал бодисын шим тэжээл амьтныхаас нэн шууд байдаг. Хүмүүс амьд амьтныг

иддэг боловч амьтны шим тэжээл нь харин ургамал бодисоос олсон юм. Ихэнх амьтдын нас тийм урт биш, хүний зарим өвчин амьтанд бас байдаг. Иймээс хүний өвчин, өвчинтэй амьтны махыг идсэний улмаас бактер нь хүмүүсийн биед орсон бололцоо их байна. Хүн яагаад ургамлаас шууд шим тэжээлээ авдаггүй юм бэ? гэжээ. Доктор Лимэ, бид зөвхөн Үр тариа, буурцаг, ногоо цагаа идвэл бүрэн гүйцэд шим тэжээлийг олж, хүний эрүүл мэндийг баталгаатай болгож чадна гэжээ.

"Амьтны уураг ургамлын уургаас илүү байдаг" гэж олон хүн хэлж байна. Амьтан бол бүрэн уураг, ургамал бол бүрэн бус уураг гэнэ. Үнэндээ зарим ургамал бодис бас бүрэн уураг юм. Хэд хэдэн зүйлийн бүрэн бус уурагт зүйлийг сайхан нийлүүлбэл бас бүрэн уураг

Үүсэж болох юм.

1988 оны 3 – р сард Америк улсын идээн ундааны нийгэмлэг (ADA) " Хэрэв хүнсний зүйлүүдийг тохируулж чадвал бацаг барих нь эрүүл мэндэд ашигтай мөртөө шим тэжээл тэнцүүртэй болдог" гэж зарлажээ.

Мах идэгчид бацаг баригчдаас чийрэг гэж зарим хүмүүс буруугаар ойлгодог. Еро их сургуулийн профессор фишер (Professor Irving Fisher) дараах туршилтыг хийхэд 32 бацаг баригчид ба 15 мах идэгчдийн дотор бацаг баригч нь мах идэгчээс нэн илүү даацтай байжээ. Туршилтад оролцсон хүмүүсийг аль болохоор гарыг нь дээш өргүүлжээ. 15 мах идэгчийн дотор зөвхөн 2 нь 15 — 30 минут гараа өргөв. 32 бацаг баригчийн дотор 22 нь гараа 15—30 минут өргөж, 15 нь хагас цаг өргөж, 9 нь 1 цаг өргөж,

4 нь 2 цаг өргөж, 1 нь бас 3 цаг өргөсөн байжээ.

Хол замын уралдаанд гүйдэг шилдэг тамирчид тэмцээний өмнө хэдэн өдөр бацаг барьдаг байна. Бацаг барилтаар өвчин эмнэдэх мэргэжилтэн эмч Бабараморе (Dr. Barbara More) 27 цаг 30 минутэд 110 мил явсан байна. Тэр 56 настай эмэгтэй хүн юм. Идэр насны хүмүүсийн рекордыг давсан байна. Түүний хэлсэн нь: "Би биеэрээ дүрэм болж, бацаг барьсан хүн бүр эрүүл чийрэг, хурц сэргэлэн, ариун цэвэр амьдралыг хийдэг гэснийг гэрчлэх гэж ингэж гүйв" гэжээ.

Бацаг барьсан хүмүүс идээн ундааны дотроос гүйцэд уураг олж чадна уу? Дэлхийн эрүүл мэндийн зохион байгуулалтын шинжилснээр бол бидний өдөр тутмын хэрэсэх илчийн 4.5% — ийг

нь уургаас авдаг. Буудайд 17%, ногоон цэцэгт наргилд 45%, цагаан будаанд 8%-ийн уураг агуулагдаж байна. Иймээс идээн ундааны зүйлсэд уураг ерөөс элбэг байх юм. Бацаг барьж мах идэхгүй хүний бас нэг сайн газар нь гэвэл, өөх идсэнээс олох олон өвчнөөс зайлж чадна. Жишээлбэл, зүрхний өвчин болон зүйл бүрийн өмөн өвчин болно. Бацаг барих нь Үнэнхүү сайн явдал юм.

Хэтэрхий арвин мах болон ханамал өөхтэй амьтны махыг идэх явдал, зүрхний өвчин, хөхийн өмөн, олгойн өмөн, тархины саа өвчинтэй нягт холбоотой гэдгийг нэгэнт нотолсон байна. Бид өөх багатай идээнийг идэж, өвчнийг сэтгийлж болно. Жишээлбэл, бөөрийн чулуушрал, булчирхайн өмөн, чихэрт шижин өвчин, шингээлтийн замын шархлалга, цөсний чулуушрал, гэдэсний

халуун, Үе гишүүний Үрэвсэл, бүйлийн
өвчин, сэвх, нойрын булчирхайн өмөн,
ходоодны өмөн, цусны чихрийн багасал,
өтгөн мөр хатах, бүдүүн гэдэсний
уутлаг, цусан даралт өндөржих, яслэг
эд сийрэгжих, өндгөвчийн өмөн,
шамбарам, тариалах өвчин, амьсгал
давхцах зэрэг. Тамхи татахыг гаргавал
мах идэхээс өөр хүний эрүүл мэндэд
хортой зүйл бараг байхгүй юм.

АМЬД БОДИС БА ОРЧИН АХУЙ

Мах идэхийн төлөө амьтан тэжээх нь
нэлээд арвин уршиг татах юм.
Жишээлбэл ой модыг эвдэх, бөмбөрцгийн
халуун дээшлэх, ус бохирдох, усны эх
сурвалж багасах, тариан гасар элсжих,
энегийг Үрэгдүүлэх, дэлхий нийтийн ган

гачиг Үүсгэх зэрэг болно. Газар, ус, энерги, ажиллах хүчийг хэрэглэж махны зүйлийг Үйлдвэрлэх явдал дэлхийн бөмбөрцгийн эх баялгийг зөв ашглаж байгаа явдал огт биш юм.

Дунд Америкт 1960 оноос эхлэн, Үхрийн бэлчээр гагахын төлөө 25% - ийн ой шугуйг галдан шатаасан байна. Үхрийн махаар 4 бутан ханбога хийх бүр 55 ам дөрвөлжин фут халуун бүсийн ой шугуйг эвдэх хэрэгтэй. Үүнээс гадна бас Үхэр бордоход гурван зүйлийн уур Үүсэж, дэлхийн бөмбөрцгийн халууныг дээшүүлэх болно. Үхэр бордох нь бас усыг бохирдуулах гол шалтгаан болно. Нэг фунт Үхрийн мах Үйлдвэрлэхэд хүнийг цоцоомоор их 2646 галлон ус хэрэглэнэ. Нэг фунт помидор Үйлдвэрлэхэд зөвхөн 29 галлон ус хэрэглэж, нэг фунт майтосе Үйлдвэрэхэд

139 галлон ус хэрэглэх болно. Америк улс бараг хагас усаа тэжээл бордоо тарих ба Үхэр зэрэг гэрийн тэжээвэр тэжээхэд Үрэгдүүлж байна.

Хэрэв Үхэр бордоход хэрэглэж байгаа эх баялгаа ашиглаж Үр тариа Үйлдвэрлэж, ХҮМҮҮСТ хангавал нэн олон ХҮМҮҮС идэх хоолтой болох юм. Хэрэв нохойн хошууг хүний идэш болгож, амьтан тэжээхэд хэрэглэхгүй бол, нэг акар тариан газарт тарьсан нохойн хошуу нь мах Үйлдвэрлэж олсны 8 дахинтай тэнцэх уураг ба 25 дахинтай тэнцэх илчийг олох юм. Хэрэв нэгэн акар газат ногоон цэцэгт наргил таривал Үхрийн мах Үйлдвэрлэж олсноос 10 дахинтай тэнцэх уураг болон илчийг олж болно. Ийм тоо баримт маш олон байгаа. Мал бордох газарт Хүнсний таримал таривал дэлхийн эх баялгийг нэн эохистой сайхан ашиглах

болно.

Бацаг барих нь таныг энэ одон гариг дээр "өр ширгүй үхтэл амгалан" болгоно. Учир нь та зөвхөн хэрэгцээтэй хэсгээ авч хэрэглэдэг бөгөөд амьтан алах явдлыг багасгаж байна. Миний идшийг хангахын төлөө амьтныг хороолоо гэж танд бодогдохгүй тул таны сэтгэл амгалан байх болно.

ДЭЛХИЙН ГАМШИГ

дэлхийн бөмбөрцөг дээр 19 дүнчүүр орчим хүн аюул гамшигт дайрагдан шим тэжээл хүрэлцэхгүй зовлонг амсаж байна. Жилд 40 сая хүн гамшигт үхэж байх бөгөөд үүний олонхи нь хүүхэд болно. Гэтэл дэлхий дээр гуравны нэг хувийн үр тариаг хүмүүст идүүлэхгүй харин малд идүүлж байна. Америк улс

тарьсан Үр тарианыхаа 70%– ийг малд идүүлж байна. Малд идүүлэх Үр тариагаа хүнд идүүлбэл өлсгөлөн хүн дахиж гарахгүй болно.

АМЬТНЫ ҮЙЛ ТАМ

Та ийм нэг явдлыг сонссон уу? Амрикт өдөр бүр 100 мянга илүү үхрийг алж байна!

Өрнө дахины улсад ихэнх амьтдаа "Үйлдвэрийн шинжтэй аж ахуй" – д бордож байдаг. Тэрхүү аж ахуйн зураг төсөл хамаг цөөн зардлаар хамаг арвин амьтан тэжээн нядлахаар зохиогдсон байна. Тэндэх амьтад нэг өчүүхэн газар шахалцаад, Үзэхэд нүд халтирмаар юм. Тэдэнд жаахан тэжээл бордоо өгчихвөл удахгүй мах болчихно. Ихэнх хүмүүс энэхүү бодитой үнэн байдлыг өөрийн

нүдээрээ олж үзэхгүй юм. Зарим хүн: " Мал нядлах газар чи нэг л удаа очиж үзвэл энэ нэг насандаа бацаг барих болно" гэжээ.

Толстой: " Мал нядлах газар байж л байвал, дайны талбай байдаг, бацаг барих нь хүнлэг үзлийн чанга шалгалт болох юм" гэж хэлжээ. Ихэнх хүмүүс амьтныг санаачлагатайгаар хороохгүй байсан ч нийгмийн орчин ахуйгаас болж үргэлж мах иддэг заншилтай болов, гэтэл бид идсэн амьтандаа юу хийж өгснөө сайн мэдэхгүй юм.

БОГД ЭРДЭМТЭН БА ЗОРИГ НЭГТ ЗОРИЛТ АДИЛ ХҮМҮҮС

Нэлээд олон бомбын шашны шавь нар бас бацаг баригч юм. Эрт үеийн Христийн шашинтан ба Еврэйин шашинтан бас бацаг

баригч юм. Энэ тухай Библийн номд маш тодорхой тэмдэглэж байдаг. Эзэн хэлсэн нь: " Үзээч! Би та нарт зүйл бүрийн өвсөн язгуурын Үр өгч, газар дээр цацуулжээ. Модны жимс ч та нарын идээн болно" гэв. Библийн номд бас мах идэхийг цээрлэж, " Гэвч амьтны мах ба цусыг та нар идэж болохгүй! " гэжээ.

Библийн номд бас: " Та намайг гуйх хэрэггүй, таны гарт тун арвин цус наалдаж байна. Та нар хонь алж намайг тахидаг, би та нарыг Үхэр, хонь алж намайг тахитугай гэж хэлсэнгүй, та нар гэмшиж даатгах хэрэгтэй. Гэмшихгүй бол би таны даатгаж гуйхыг сонсохгүй, Үйл түйтгэрийг чинь уучлахгүй" гэжээ. Есүс – Христийн их шавийн нэг болох Санфолове, Ромчуудад өгсөн захиандаа: " Мах идэхгүй бол хамгийн сайн бөгөөд бас архи ууж болохгүй" гэжээ.

Ойрд түүхчид тун арвин ном олжээ. Тухайлбал Библийн номын Шинэ гэрээ болно. Үүнд Есүс Христийн амьдрал, ярианы тухай тэмдэглэжээ. Есүс хэлсэн нь: " Хүмүүс хээрийн амьтны махыг идвэл хожим түүний хүүр нь болж хувирна. Би та нарт үнэн үг хэлж өгье, тэдгээр хүн алагч бол өөрийн биеэ алж байх юм. Амьтныг хороож мах идэгч бол үхсэн хүний махыг идэж байгаа явдал болно." Энэтхэг шашин бас мах идэхийг цээрлэдэг, " Хүмүүс амьтныг хорлож идшин махаа олж бий, мэдрэлтэй амьтныг хорлосон хүн тэнгэрийн ивээлийг үүрд олж чадахгүй. Иймээс мах идэхээс зайлаарай." гэсэн байдаг. (Энэтхэг шашны сахилга)

Исламын шашин(хотонгийн шашин) — ы ариун ном — Кураны сударт бас " үхсэн амьтны цус ба мах..." — ыг

идэхийг цээрлэжээ.

Хамаг эртний тэмдэглэсэн түүхнээс үзэхэд бацаг барихыг байгалийн идээн ундаан идэхээр үздэг. Эрт үеийн Грек, Египет, Еврейн домог ярианд хүн төрөлхтөн уг язгуураасаа цөм жимсний зүйлийг иддэг гэжээ. Эртний Египетийн оюун ухаантан лам хувраг хэзээд мах иддэггүй. Грекийн нэлээд олон агуу их оюун ухаантан — фалатон, Дайожян, Сократ цөм бацаг барихыг сайшаадаг. Энэтхэгийн будди Ahimsa (амь хороохгүй) — ийг чухалчилж, амьтныг хорлохгүй, айлгахгүйн төлөө мах идэж болохгүй гэж шавь нараа дахин давтан сургадаг байна.

Будди дараахь шүүмжийг хийв: " Мах идэх нь хожим буй болсон нэгэн зүйлийн дадгал болно, бид төрмөгцөө мах идье гэж бодох биш ", " Мах

идэгчдийн их нигүүлсэнгүйн Үр нь тасарна", " Мах идэх хүмүүс хоорондоо алалцаж идээд, энэ төрөлдөө би таныг идэж, ирэх төрөлдөө та намайг идэж... өнө Үүрд дуусахын аргагүй. Ийм хүмүүс яаж гуравдугаар ертөнцөөс давж чадах вэ?" гэжээ. Уг зохиолын Баатар явагч их хөлгөн судрын доторхи Үйл Үрийн харилцан Үргэлжлэх гэдэг нэгэн бадагт Бурхан: " Энэ мэтээр ховдоглон нядалж, хонь нядлагдан идэгдэж, Үхсэн хонь нь дахин хүн болж, арван зүйлийн амьтдын Үхэж төрөх нь ээлжлэн, харилцан идэлцэж, муу Үйл бүхнийг Үйлдэж дуусашгүй", " Та нар мэдэх хэрэгтэй, мах идэгчид самадайн баяслыг олсон мэт тааламжтай боловч бүгдээр рагса чөтгөртэй адил эцстээ Үхэж төрөхийн гаслангийн далайд тунаж, бурхны шавь Үл болмой. Ийм хүмүүс

хоорондоо алалдан харилцан залгиж, өөр зуураа идэлцэх нь дуусахгүй тул гуравдууар ертөнцөөс давахыг хэрхэн өгүүлэх ажээ" гэжээ.

Хятад улсын нэгэн их дияанч Хань Шаньзы мах идэхийг эсэргүүцсэн нэгэн бадаг шүлэгтээ: "Эрээн гэдсээ эрхэмлэж загас худалдан аваад, өрх зүгээ дамнан эхнэр хүүхдээ тэжээхэд, эдний амийг нядлах хэрэг юун. Энэ бие чинь хожим түүн лүгээ адил, тэнгэрийн орны барилдлагаас холдож, тэр чигээрээ тамын хог новш болно" гэжээ.

Маш олон алдарт зохиолч, урлагчид, шинжлэх ухаантан, философич нар бараг бүгдээрээ бацаг барьдаг бөгөөд бацаг барихын чухалчлалыг хүчтэй ухуулж байжээ. Үүнээс жилшээ болгон дурдвал, Шагзамунь, Есүс — Христ, Вейзар, Хорис, Палатон, Эуит, Питуверик,

Битакрас, Сократ, Шаксперт, Бурер, Нютон, Вавейсе, Дарвин, Фуранкалин, Айморсон, Суверуве, Шувелай, Айстан, Тагурай, Толостой, Шобеканк, Ганди, Ши Хуайжэ болон ойрмог Үеийн Полониёман, Матанна, Дайнна вангийн хатан, Линсайхувана, Поломайкани, Гандиспу нар болно.

Айнстан: " Миний үзэхээр бацаг баригчдын сэтгэлгийн хувиралт ба ариутгал нь хүн төрөлхтөнд маш ашигтай юм. Иймээс бацаг идээн хүн төрөлхтөнд сайн ёртой" гэжээ. Бацаг барих нь эрт эдүүгээгийн маш олон эрдэмтэн мэргэдийн хамтын сугаал болно.

БАГШИЙН ХАРИУЛТ

Асуулт: Амьтныг идэх нь яриангүй амьтныг хорооно. Ургамлыг идэх нь бас

амьтныг хороож байгаа биш үү?

Хариулт: Ургамлыг идэх нь мөн амьтныг хороож байгаа явдал мөн боловч үйл түйтгэрээр нэлээд бага юм. Өдөр бүр Арявалын номын цогцсын бясалгалыг 2 цаг хагас хийвэл, энэ үйл түйтгэрийг арилгаж чадах болно. Бид хоол идэхгүй байж болохгүй тул мэдрэлээр хамаг доор зовуураар хамаг бага амьд бодисыг сонгож идэх хэрэгтэй. Ургамал бодисын 90% — иас дээших нь бүр ус, мэдрэлийн эс маш цөөн, бараг зовох сэтгэгдэл гарахгүй юм. Бид ургамлын салаа намааг авах нь бэлгийн бус үржлийг ахиудаг байна. Энэ нь үнэндээ ургамал бодист сайн болдог юм. Цэцэрлэгийн судлалд цэцэг модыг цөм хайчлан засаж байвал түүний ургац нь улам сайжирч, нэн үзэмжтэй болдог гэж байдаг. Жимсээр авч хэлбэл, боловсрох Үедээ анхилмал Үнэр гарах

бөгөөд шинэ сайхан өнгөтэй болдог юм. Таатайхан амт шимт нь бидний дурыг хүргэдэг. Жимсний мод ийм аргаар дөрвөн зүгт Үрээ дэлгэрүүлж тариулах зорилгодоо хүрдэг билээ. Бид түүнийг түүн авчирч идэхгүй бол хэт боловсроод газарт унаж ялзраад, бүдүүн модны доор нар тусахгүй тул Үр нь ургаж чадахгүй болдог. Иймээс ургамал бодис, хүнсний ногоог идэх явдал нэг зүйлийн байгалийн хэрэгцээ болох бөгөөд түүнд звч хэлбэл ямар ч зовуургүй юм.

Асуулт: Бацаг барьдаг хүний бие хатанхир, буурай, мах иддэг хүний бие нэлээд өндөр, бүдүүн гэж хүмүүс үзэж байна. Энэ таарна уу?

Хариулт: Бацаг барьдаг хүний бие лавтай хатанхир, буурай гэсэн биш юм. Шим тэжээлээ тохируулж чадвал нэгэн адил өндөр, хүдэр болж чадах болно.

Буй бүхий бүдүүн амьтдыг та үзээч, жишээлбэл заан, Үхэр, анааш, адуу, усны морь зэрэг зөвхөн жимс, ногоо иддэг амьтад нь мах иддэг амьтдаас чийрэг, хүч чадалтай, сайн санаатай бөгөөд бас хүн төрөлхтөнд ашигтай юм. Мах иддэг амьтан бол хэрцгий, догшин бөгөөд хэрэгцээгүй юм. Хүмүүс амьтныг арвин идвэл адгуусан амьтны муу зан аашид нь нөлөөлөгдөх юм. Мах иддэг хүний бие нь лавтай өндөр, бүдүүн гэсэн биш, дундаж амь нас нь харин тун богино байдаг. Эскимосчууд махан идшээр голлодог. Тэд өндөр, бүдүүн байна уу? Урт насалж байна уу? Үүнийг та нар лав тодорхой мэдэх ёстой.

Асуулт: Бацаг барьдаг хүн өндөг идэж болно уу?

Хариулт: Болохгүй. Бид өндөг идвэл бас л амьтныг хороож байгаа явдал

болохгүй юү? Дэлгүүрт худалдаж байгаа өнгөг цөм Үр тогтсонгүй өндөг тул идэвч амьтныг хороосондоо орохгүй гэж зарим хүн хэлж байна. Сонсоход зөв шиг боловч Үнэндээ буруу онол болно. Үр тогтсонгүй өндөг бол барилдлага нь гүйцэдгүй учраас тахиа болж чадахгүй байна. Гэвч тэр бас амиллын хүчинтэй байдаг. Өндгөн дэх уураг, фосфор хүний биеийн шим тэжээлд дутагдаж болшгүй зүйл мөн. Гэвч дүүпүүнд уураг байна, зарим ногоонд бас фосфор байдаг. (Төмсөнд фосфор байна)

Эртэн эдүүгээхийн мэргэд, хуушаан нар мах, өндөг идэхгүй байснаас олонхи нь урт насалжээ. Жишээлбэл, Ингуан их багш, хоол болгондоо зөвхөн нэг аяга ногоогоор зууш болгодог байсан боловч 80 нас хүрсэн байна. Өндгөн шард их өндөр хэмжээний цөсөн алкоголь агуулагдаж,

зүрхэн судасны өвчнийг хялбархан олгодог юм. Энэхүү өвчин нэгэнт Америк, Тайваньд хамаг арвин тохиолддог өвчин болжээ. Иймээс эмнэлэгт хэвтэж байгаа хүмүүсийн олонхи нь бүр өндөг иддэг, хүмүүс байдаг байна.

Асуулт: Гахай, үхэр, тахиа, нугас зэргийг цөм бид тэжээж өсгөсөн юм, яагаад идэж болдоггүй юм бэ?

Хариулт: Тийм бол хүүхдийг бас эцэг эх нь тэжээж өсгөсөн тул эцэг эх нь хүүхдээ идэх эрхтэй юү? Амьд бодис цөм төрж орших эрхтэй байдаг, ямар ч хүн тэдний төрж орших эрхийг булааж болохгүй. Гонконгийн хуулиар бол амиа хорлосон хүнийг ч ял хийснээр тооцох юм. Бусад амьтны амийг хороож нэн болохгүй шүү дээ.

Асуулт: Амьтан угаасаа хүн

төрөлхтөнд идэгдэхээр төрсөн юм. Идэхгүй бол бүх дэлхий мал адгуусаар дүүрчихгүй юү?

Хариулт: Энэ чинь шал дэмий онол байна. Бид гахай, үхрийг алахдаа түүнээс бидэнд идэгдэх дуртай юу гэж асуусан удаа байна уу? Амьтан бүхэн цөм үхэхээс айж, амьдрахыг хүсдэг юм. Бид бард идэгдэх дургүй байтал юуны учраас амьтан бидэнд идэгдэх ёстой юм бэ? Хүн дэлхийн бөмбөрцөг дээр буй болоод хэдэн зуун мянган жил болсон төдий л шүү дээ. Хүн төрөлхтөн дэлхийд буй болохоос өмнө маш арвин амьтад дэлхий дээр байжээ. Тэд дэлхийн бөмбөрцгийг дүүртэл шахалдсан удаа байна уу? Амьд бодист цөм тэндий байгалийн амь ахуйн тэнцүүр гэж байдаг. Тоо хэмжээ дэндүү олон болох үед идэх бодис ба орших тойрондоо

хязгаарлагдаж, тоо нь хасагдаж, аяндаа зохих тоо хэмжээтэй болчихдог.

Асуулт: Юуны учраас би бацаг барих ёстой вэ?

Хариулт: Би бацаг барих нь миний дотоодын хаан хурмаст мамайг хийлгэсэн юм. Мэдэв үү? Мах идэх явдал орчлонгийн жам ёсыг зөрчөнө. Бид өөрөө бусдад алагдах ба хулгайлагдах дургүй. Бид хэрэв бусдыг ингэхэд хамаагүй гэж бодвол, өөрийн уг санаагаа зөрчсөн явдлыг хийж, өөрийгөө зовууртай болгож, бусдыг хорлосон хэрэг нэг бүр чинь таныг зовлонд оруулах болно. Та өөрийн биеэ лав хазахгүй бөгөөд гэмтээх ч дургүй биз? Үүнтэй адилаар та амьтныг хороож болохгүй, хороовол амь насны тухай хуулийг зөрчсөн явдал болно. Ойлгов уу? Бид ингэж болохгүй, ингэвэл биднийг зовлонд унагах юм. Энэ

зөвхөн өөрийн биеэ хязгаарлаж байгаа явдал биш, бид өөрийн амь насаа бусад амьтантай адил нандигнаж байгаа явдал юм. Бидний амь нас зөвхөн энэ биедээ холбогдох биш, амьд бодис болон буй бүхий амьтны амь насанд холбогдох юм. Энэхүү үзэл бодол биднийг нэн эрхэм дээд, нэн агуу их, нэн баяр баясгалантай болгох юм. Тийм биш үү?

Асуулт: Та бацаг барих тухай ярьж өгнө үү? Бацаг барихыг яагаад дэлхийн энх тайванд ашигтай гэдэг вэ?

Хариулт: Энэ асуулт их сайн боллоо. Та үзээч! Дэлхийн ихэнх дайн нь цөм эдийн засгийн шалтгаанаас болдог юм. Энэ бол бодитой явдал мөн, бид заавал үнэнээр нь ярих хэрэгтэй.

Ямар нэгэн улсад гамшиг гарч Үр тариа дутагдах буюу улс хоорондын Үр тарианы хуваарилалт тэнцүүргүй болоход

хүрвэл, тухайн улсын эдийн засаг нь хүндрэлтэй болох юм. Та сонин сэтгүүл сайн үзэж, бацаг барих тухай шинжилгээний зохиолуудыг уншвал мэдэж болож байна. Бид мах идэхийн төлөө амьтан тэжээгээд, эдийн засгийг сүйрүүлж, дэлхийн олон газар аюул гамшиг болгож байна. Наад зах нь гуравдугаар ертөнцийн орнуудад ийм байна.

Энэ зөвхөн миний өөрийн санал биш юм. Нэг америк хүн энэ тухай шинжилгээ хийж нэг ном бичсэн байдаг. Та ямар нэгэн номын дэлгүүрт очиж, бацаг барих тухай судалгааны ном болон хоол идэш боловсруулах тухай номыг авч уншиж болох юм. Та Жонробиншийн бичсэн "Америкийн шинэ идээн ундаан" гэдэг номыг үзээрэй. Тэр бол нэгэн алдарт айскурим үйлдэгч юм. Гэвч бацаг

идэхийн тусад аливаа бүхнээ орхиж, айл гэрийн уламжлал ба өөрийн хийж байсан ажилтайгаа яг эсрэг бацаг барих тухай номыг бичжээ. Энэ хүн их арвин мөнгө зоос, ажил төрөл, нэр төрийн хохирлыг бодсонгүйгээр Үнэн ёсны төлөө аливаагаа зориулсан байна. Түүний бичсэн энэ ном их сайн ном юм. Бас бусад арвин ном сэтгүүл танд бацаг барих тухай мэдлэгийг олгож, бацаг барих нь яагаад дэлхийн энх тайванд ашигтай болохыг хэлж өгөх болно.

Бид үхэр бордохын төлөө өөрийн хүнсээ сүйтгэж байхыг та үзээч. Нэг үхрийг бордон тэжээж, алж идэх болтол хэчнээн уураг, ус, ажиллах хүч, эмийн зүйл, жижиг машин, том машин зэргийг хэрэглэхээс гадна бас зам тавих хэрэгтэй, мянга түмэн акар тариан газрыг эвдэх хэрэгтэй болдог. Та мэдэх үү? Эдгээр эд

материалыг хөгжөөгүй улс орнуудад хувааж өгвөл, аюул гамшгийг шийдвэрлэж чадах юм. Ямар нэгэн улсад хүнсний зүйл дутагдвал, өөрийн ард түмнийхээ төлөө тэр улс бусад улсад түрэмгийлэн орох бололцоо байна. Энэ явдал урт удаан хугацаа үрэлжилбэл муу үйл үр бүрэлдэх болно. Ойлгов уу? " Ямар үйлийг таривал тийм үрийг хураах юм ". Бид одоо хүнс хоолны төлөө амьтныг хороож байвал, дараа удаа, дараах төрөлдөө бас өөр нэгэн хэлбэрээр алагдаж бусдын хүнсний зүйл болох юм. Үнэхээр аюултай биз? Бид ийм цэцэн сэргэлэн, ийм боловсон байж байгаад манай ихэнх хүмүүс харин сэргэлдээ улсынхаа гаслан зовлонтой байхыг яагаад мэдэхгүй байна. Энэ чинь цөм л хоол хүнсний хангалгын асуудлаас болж байна. Бид тийм арвин амь хороогоод, энэ

биеэ тэжээж, тийм арвин ах дүү нараа өлсгөж байна. Би бас амьтны амь насны тухай асуудлыг яриагүй байна. Мэдэв үү?

Энэхүү хомхой сэтгэл нь санаачлагатай ба санаачлагагүйгээр бидний үзэл санааг доройтуулж, биднийг өмөн, уушигны сүрьеэ, "HIV" зэрэг эмчилгээ авахгүй өвчнөөр нэрвэгдүүлэх аюултай болгоно. Та нар өөрийн биеэсээ асууж үзээрэй, юуны учраас танай улс—Америк улс өмөн өвчинд нэрвэгдсэн нормаараа дэлхийд хамгийн өндөр байдаг вэ? Учир нь Америк улсын хүмүүс маш арвин үхрийн мах идсэн байна. Тэдний идсэн үхрийн мах аль ч улсаас арвин байдаг. Бас өөрийн биеэсээ асуугаарай, юуны учраас Хятад улс ба коммунизмын улсуудад өмөн өвчин олох хүмүүс тийм арвин биш байдаг вэ? Учир нь тэдэнд идэх тийм

арвин Үхрийн мах байхгүй юм. Ойлгов уу? Шинжилгээний дүнд ингэж гарсан юм, миний дураараа хэлсэн юм биш, намайг битгий зэмлээрэй.

Асуулт: Бацаг баривал оюуны талаар ямар ашиг тус олох вэ?

Хариулт: Энэ асуултыг асуусанд би их баярлаж байна. Та оюуны талын ашиг тусдаа анхааран сэтгэл тавьж байгаа юм байна. Олонхи хүмүүс бацаг барих тухай асуухдаа зөвхөн эрүүл мэнд, хоол унд, бие бялдар зэрэг талыг л боддог. Хаан хурмаст " амьтныг хороож болохгүй " гэсэн нь зөвхөн хүнийг алж болохгүй гэснийг хэлсэн биш, ямар ч амьтныг алж хорлож болохгүй гэснийг хэлжээ. Түүний хэлсэн санаа нь биднийг буй бүхий амьтны найз болгож, биднээр туслуулах гэсэн биш үү? Биднээр амьтныг харгалзуулах гэсэн биш үү? Тэр

бас: "Тэднийг харгалзаж тэднийг хамаарах хэрэгтэй" гэжээ. Та ард иргэдээ захирахдаа алж иддэг үү? Хэрэв алж иддэг бол та ард иргэдгүй улсын хаан болно доо!

Одоо та хаан хурмаст юунд ингэж хэлснийг мэдсэн биз? Ийм л байх хэрэгтэй, сэжиглэх хэрэггүй. Түүний хэлсэн нь нэгэнт тун тодорхой байна. Гэвч хаан хурмастаас гадна бас хэн гэдэг хүн хаан хурмаст болохыг мэдэх үү? Хаан хурмастыг ойлгохын тусад та өөрөө эрхбиш хаан хурмаст болох хэрэгтэй.

Та бүхнийг дахин буцаж хаан хурмаст болохыг би хүсье. Та өөрийн угийн хүнээ болох хэрэгтэй, хосгүй хүн болох хэрэгэй." Хаан хурмастад наманчлах хэрэгтэй", таныг хаан хурмастыг шүтэх хэрэгтэй гэсэн биш, харин та өөрөө хаан хурмаст болж, та

өөрөө хаан хурмасттай ижил бие мөн байхаа ойлгох хэрэгтэй гэсэн явдал болно." Би өөрийн эцэгтэйгээ ижил бие мөн" гэж Есүс хэлсэн биш үү? Түүний хэлэхээр тэр эцэгтэйгээ ижил бие болоход хүрвэл, бид бас түүний эцэгтэй ижил бие болох юм. Учир нь бид бас хаан хурмастын Үр хүүхэд мөн юм. Есүсийн хэлснээр бид бас түүнээс нэн сайн болох ч юун магад. Иймээс бид хаан хурмастаас нэн сайн байж болно, энэ чинь болохгүй юм биш ээ. Хэрэв бид хаан хурмастад өчүүхэн ч ойлголтгүй бол юунд бас хаан хурмастыг шүтэх юм бэ? Юунд бас итгэдэг юм бэ? Бид юуг шүтэхээ урьдаар мэдэх хэрэгтэй. Гэрлэхээсээ өмнө гэрлэх гэж байгаа хүүхэн хэн байхыг урьдаар мэдэж авахтай адил юм. Одоо цаг үед ер нь болзоогүйгээр гэрлэхгүй юм. Иймээс хаан хурмастыг учир шалтгаангүйгээр

шүтдэггүй юм. Хаан хурмаст бидний төлөө мэндэлсэн тул бидэнд танигдахыг хүсэж байна. Бид бас дагаж явах хурмастаа сонгох эрхтэй юм. Библийн номд тодорхой заасан ёсоор бацаг барих хэрэгтэй. Аливаа бүхнийг энх амгалан байлгахын төлөө бацаг баривал зохино, шинжлэх ухааны нотлолыг үндэслэн бацаг баривал зохино, эдийн засгаа бузгайруулахын төлөө бацаг баривал зохино, энэрэнгүй санааны үүднээс бацаг баривал зохино, бүх дэлхийг туслахын төлөө бид бацаг баривал зохино.

Бас нэг шинжилгээний дүнд дурдсан нь: Хэрэв америкчууд 7 хоногт 1 удаа бацаг барихад хүрвэл жил бүр 16 сая өлсгөлөн хүнийг аварч чадна гэнэ. Иймээс баатар болох гэвэл бацаг барих хэрэгтэй. Таныг саяын хэлсэн олон зорилтыг надаас сурсангүйгээр бодъё,

нэгэн адил номын цогцсыг
бясалгасангүйгээр бодъё, гэвч өөрийнхөө
төлөө, дэлхийн ард түмний төлөө таныг
бацаг барихыг хүсэж байна.

Асуулт: Олноороо цөм ургамал бодис
идвэл Үр тариа хүрэлцэхгүй явдал
болохгүй юу?

Хариулт: Тийм явдал болохгүй. Мал
амьтан тэжээж хүмүүст мах хангах
тариан газрыг ургамал тарьж хүн тэжээх
тариан газартай харьцуулбал, мал тэжээх
тариан газар нь ургамал тарьж хүн тэжээх
тариан газраас 14 дахин илүү байна. 1 Үр
тариан газрын ургамал бодисоос Үүсэх
энерги нь 800 мянган калори байдаг,
хэрэв эдгээр ургамлаар урьдаар мал
тэжээвэл, зөвхөн 200 мянган калори
Үүсэж, хооронд нь 600 зуун мянган
калори энерги талаар сүйдэх болно.
Иймээс бсцаг барихын эдийн засгийн ашиг

тус нь мах идэхээс нэн их юм.

Асуулт: Бацаг барихад загас идэж болно уу?

Хариулт: Та загас идье гэж бодож байвал идээрэй. Гэвч та бацаг барья гэж бодож байвал загас бацаг идээн биш гэснийг мэдэх хэрэгтэй.

Асуулт: Хүн сайн сэтгэлтэй бол бацаг барих чухалгүй гэж хүмүүс ярицгааж байна. Энэ зөв үү?

Хариулт: Хэрэв сайн сэтгэлтэй бол юу гэж амьтны махыг иддэг вэ? Амьтан бүхний энэлэл шаналлыг бодмогцоо өрөвдөж, махыг нь идэхгүй бол зүйтэй. Мах идэх нь нигүүлсэнгүйг тэвчсэн хэрэг юм. Яаж сайн сэтгэлтэй гэж хэлэх вэ? Их багш Ляньчы өгүүлсэн нь: "Амь нядалж мах идэх нь, тэнгэрийн доор харгис сэтгэл, хэрцгий бодол, хорт санаа, хар сэтгэл бүхнээс хол давсан юм.

Сайн санаа нь хаа байх вэ?" гэв. Мэнз өгүүлсэн нь: "Төрөхийг үзээд, үхэхийг нь харвал Үл сэтгэл түвдэх, дууныг нь сонсчихоод, махыг нь идэхэд Үл сэтгэл түвдэх, эрхэм хэмээгдбээс гал тогоон гэрээс хол зайлагтун" гэжээ. (Мэнзийн Лянгүйван бүлэг зохиол) Хүн төрөлхтний оюун ухаан амьтнаас илүү тул зүйл бүрийн багажийг хэрэглэдэг. Амьтад хүнтэй тэмцэх чадалгүй тул хорслоо өвөрлөн үхдэг байна. Энэ мэтээр дорой буурайгаа дарладаг хүн бол эрхэм дээд болох хэргүй юм. Амьтан алагдахдаа туйлаар айх, хилэгнэх, хорсох тул түүний биенээс их арвин хорт бодис үүсэж, маханд нь шингэж үлддэг. Хүмүүс идсэний дараа хордохын хамт амьтны доор давтамжит долгио нь бидний биед нөлөөлж оюун мэдрэлийн хөгжилтөт муу роль гаргаж мэдэх юм.

Асуулт: Махтай хамт чанасан ногоог идэж болно уу?

Хариулт: Болохгүй. Хэрэв идэх юмыг хорт эмэнд норгоод гаргаж идвэл хордогдохгүй юү? Няравны номд Гашив Бурхнаас асуусан нь:" Хэрэв бадар барихад мах холилдсон байвал яаж идэх вэ? Цэвэрлэх арга байна уу? гэсэнд Бурхан хэлсэн нь:" Усаар угааж махыг нь ялгаж гаргасны дараа идэж болно " гэв. Үүнээс үзэхэд махтай хамт байгаа ногоог усаар угаан цэвэрлэхгүй бол идэж болохгүй. Махыг үл идэхийг хэлэхийн хэрэг юу байх вэ. Энэхүү асуулт хариултаас Шагзамунь бурхан ба түүний шавь нар нь цөм бацаг барьдгийг бид мэдэж болно. Зарим хүн харин Шагзамунь бурхныг амархан бацаг иддэг, өглөгийн эзэн мах өгвөл идчихдэг гэж хэлэв. Энэ огт баримтгүй худал үг болох бөгөөд ном

судар уншсангүй буюу номын ёсыг мэдэхгүйтэй холбоотой юм. Энэтхэгт 90% - иас дээшийн хүн бацаг барьдаг. Тэд шар хувцастай хүн ирж бадар барихыг үзмэгц цөм бацаг өгөхийг мэднэ. Тэдний гэрт бас өгөх мах байхгүй юм.

Асуулт: Шагзамунь бурхан гахайн шийр идээд чацга алдаж байсан гэж зарим номын багш ярьдаг, энэ үнэн үү?

Хариулт: Огт байхгүй явдал. Шагзамунь бурхан нэг зүйлийн мөөг идээд нас нөгчжээ. Нэгэн зүйлийн мөөгийн нэрийг шууд орчуулбал гахайн шийр болно. Тэр гахайн шийр жинхэнэ гахайн шийр биш юм. Манай энд нэг зүйлийн жимсийг луугийн нүд гэдэгтэй адил юм. Маш арвин идээний нэр нь хэдийгээр улаан идээний нэр боловч үнэндээ бацаг идээ байдаг. Жишээлбэл луугийн нүд болно.

Нэг зүйлийн мөөгийн санскрит хэлний утга нь гахайн шийр буюу гахайн дурай зүйл гэдэг, гахайтай холбоотой юм. Тийм мөөгийг Энэтхэгт эрт үед эрж олоход тун бэрхтэй бөгөөд туйлын ховор нандин юм. Энэ жимс амтат идээний зүйл болдог учраас Үнэнч сэтэлтэй хүмүүс түүнээр Шагзамунь бурхныг тахидаг байна. Ийм мөөг ил ургадаггүй, хөрсөн доор ургадаг. Хэрэв түүнийг эрж олъё гэвэл заавал бүдүүн гахайтай хамтаар эрэх хэрэгтэй, Гахай тийм мөөгийг тун идэх дуртай тул гахай дуртай гэдэг. Гахай түүний байх газрыг Үнэртмэгц тэр доороо малтаж аваад иддэг байна. Гахай түүнийг идэх тун дуртай тул Энэтхэгт тэр мөөгийг гахайн шийр буюу гахай дуртай гэдэг.

Хоёр нэр нь бүр адил нэг зүйлийн мөөгийг зааж байгаа. Манай орчуулагчид

Үлгэрийн утгыг нь бүрэн ойлгосонгүй учраас буруу орчуулж, хойчийн хүмүүст буруу ойлголт өгч, Шагзамунь бурхныг мах иддэг бурхан болгосон байжээ. Энэ бол тун эвгүй явдал болсон юм.

Асуулт: Зарим ховдог хүмүүс, тусгай мал алдаг айлын алсан амьтныг авч идвэл амь үл хороох сахилыг зөрчсөнд орохгүй гэж байна. Энэ үг таарна уу?

Хариулт: Маш буруу юм. Мах идэх хүн байх учраас мал алах айл байдаг гэснийг мэдэх хэрэгтэй. Ланка сударт Бурхан хэлсэн нь: "Амьтан алах нь олонхидоо хүнд идүүлэхийн төлөө юм. Хэрэв хүн идэхүй бол амьтан алах явдал алга. Мах идэх ба амьтан алах нь нэгэн адил ялтай." гэжээ. Амьтныг дэндүү арвин алсан учраас байгалийн гамшиг, бусад аюул зовлон гардаг. Дайн дажин ч

бас амьтан алсан түйтгэр хэтэрхий хүнд болсноос гарч байна.

Асуулт: Ургамал бодис хэдийгээр шээсэн хүчил, шээсний эд зэрэг хорт бодисыг үүсгэн хүний биеийг хорлодоггүй боловч тарианд цацсан хорхойн хор хүний биед ашиггүй гэж зарим хүмүүс ярьж байна. Энэ зөв үү?

Хариулт: Хэрэв тарианд хорхой алах химийн хор буюу DDT зэрэг хорыг сүрчсэн бол хүний биед хортой. Өмөн өвчин, үл жирэмслэх өвчин, элэгний өвчин зэргийг олгох болно. DDT зэрэг эм өөхөнд уусдаг учраас амьтны биеийн өөхөнд хадгалагдана. Агшсан хор болон бусад хор амьтны өсөж бойжихтой хамтаар амьтны өөхөнд 5 сар хадгалагддаг байна. Та эдгээр химийн бодисыг махтай хамт иднэ. Амьтны биед агуулагдаж болох DDT - ын хэмжээ,

ногоо, жимсэнд агуулагдах DDT - ын хэмжээний 13 дахин байдаг. Ургамлын өнгөн талын хорыг угааж арилгаж болно. Амьтны өөхөн дотор хадгалагдсан хорыг угааж арилгаж яасан у чадахгүй. Учир нь эдгээр хорт бодис удаан өдөр хадгалагдсан байна. Хамаг дээд зэргийн хэрэглэгчид бол хамаг их хорлогдогч болно. Иува муж улсын их сургуулийн хийсэн туршилтат дараах дүн гарсан байна: Хүний бие дэх тарианы хорын ихэнх нь идшин махнаас буй болсон. Бацаг баригчдын биед агуулагдаж байх хорын хэмжээ нь мах идэгчдийн хагаст ч хүрэхгүй. Махан дахь хор өдийхнөөр зогсохгүй. Малыг түргэн таргалуулах, махны өнгө, ширхгийг хувируулах, хялбархан ялзрахгүй болгох зэрэг зорилгоор малд маш арвин химийн бордоо идүүлдэг байна. Азотын хүчилт давсаар

Үйлдсэн ялзаллыг сэргийлэх эм хороор хамгийн их юм. 1971 оны 7 - р сарын 18 - ны өдрийн "Нью - йорк таймс" сонинд:" Идээн хэрэглэгчдийн эрүүл мэндийн хамгийн их далд аюул бол бидэнд үзэгдэхгүй бохирдсон идээн болно. Жишээлбэл, самөн загасны бактер, хорхой алах хор, ялзрахыг сэргийлэх эд, гормон, бактер дарах эм болон бусад зүйлийн химийн хорын үлдэгдэл болно" гэж мэдээлжээ.

Үүнээс гадна бас махан дотор амьтны хижиг өвчнийг сэргийлэхийн тул тарьсан вакцин агуулагдаж байдаг. Харин хальслаг жимс, буурцаг, амуу будаа, цагаан идээг махан идээнтэй харьцуулбал тун цэвэр юм. Эдгээр зохиомол нэмэлт бодисууд өмөн болон бусад өвчнүүдийг хүмүүст олгодог гэж шинжилгээний дүн нотолсон билээ. Эдгээр хорт бодис бас

гэдсэн дэх хүүхдийг эрэмдэг зэрэмдэг болгодог юм. Ийм учраас жирэмсэн эмэгтэйчүүд ариун цэвэр бацаг барьж, сүү илүүхэн ууж кальци авч, буурцаг идэж уураг авч, ногоо жимс илүүхэн идэж витамин болон эрдэсийн зүйлийг олж аван, хүүхдийнхээ эрүүл мэндийг баталгаатай болгох хэрэгтэй гэжээ.